

“НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

1. Олон улсын зохицуулалт

2025 оны байдлаар дэлхийн хүн ам ойролцоогоор 8.1 тэрбум байгаагаас 6 орчим тэрбум хүн буюу дэлхийн нийт хүн амын 74 хувь нь интернэт хэрэглэж байна. Ойролцоогоор интернэт хэрэглэгч гурван хүн тутмын нэг нь 18-аас доош насны хүүхэд байна.¹

Коронавируст халдвар /Ковид-19/ өвчний улмаас дэлхийн нийт оюутан, сурагчдын 99 хувь буюу 1.7 тэрбум хүүхэд танхимын хэлбэрээр сургалт явуулах боломжгүй болж цахим хэлбэрээр сургалтыг үргэлжлүүлсэн нь тодорхой үр дүнд хүрч цаашид өргөжин хөгжиж байна.²

Гэвч ДЭМБ-ын судалгаагаар жил бүр 200 сая хүүхэд бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн золиос болдог байна. Үүний тодорхой хувь нь нийгмийн сүлжээнд үйлдэгдэж, жилээс жилд хувь хэмжээ нь нэмэгдэж байгаа бөгөөд интернэт орчин нь мөлжлөг, хүчирхийллийн талбар болж байна. <https://gia.gov.mn/12/item/709> Иймээс цахим орчин, интернэт хэрэглээг эрх зүйгээр зохицуулахын зэрэгцээ технологийн шийдлийн хувьд зохицуулах нь илүү оновчтой болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байна.

Олон Улсын Цахилгаан холбоо (ITU)-ны байгууллага “Хүүхдийг Нийгмийн сүлжээнд хамгаалах удирдамж”-ийг 2020 онд шинэчлэн гаргасан бөгөөд “Хүүхдэд зориулсан удирдамж”-аараа цахим орчны эрсдэл, боломжуудыг ойлгуулах, өөрсдийгөө хамгаалах арга замуудыг заах, “Эцэг эх, багш нарт зориулсан удирдамж”-аараа Хүүхдүүдийн цахим орчны хэрэглээг хэрхэн дэмжих, удирдан чиглүүлэх талаар практик зөвлөмжүүдийг агуулсан.

НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороо нь 2021 онд Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцын Ерөнхий Тайлбар №25-ыг баталсан. Энэ тайлбар нь хүүхдийн эрхийг дижитал орчинд хэрхэн хамгаалах талаар дэлгэрэнгүй зааварчилгаа өгсөн. Тухайлбал тус тайлбарт хүүхдүүдийг нийгмийн сүлжээнд аливаа хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах, хувийн нууцыг хадгалах, насанд нь тохирсон мэдээлэл, үйлчилгээ авах эрхийг хангах зэрэг асуудлуудыг хөндсөн.

Австрали улс:

2015 онд “Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай” хуулийг баталсан бөгөөд 2021 онд өргөжүүлж “Цахим аюулгүй байдлын тухай” хуулийг

¹ /<https://www.unicef.ch/en/what-we-do/national/digitalization/>

² /https://gia.gov.mn/12/item/709#_ftn1/

баталсан ба тус хууль нь 2022 оны 1 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Тус хууль нь нийт 16 хэсэг, 240 зүйл бүхий 209 хуудаснаас бүрдэх төрөлжсөн хууль юм.

Энэ хуульд 2024 оны 12 дугаар сард өөрчлөлт оруулсан бөгөөд тус өөрчлөлтөөр 16 хүртэлх насны хүүхдийн цахим хэрэглээг бүрэн хаахаар зохицуулсан. Австралийн хүүхдүүдийн 80 хувь нь Meta, TikTok, Instagram, Snapchat зэрэг платформыг ашигладаг бөгөөд ямар нэгэн насны хязгаарлалт байхгүй, хяналтын механизм хангалтгүй зэргээс шалтгаалан насанд хүрээгүй хүүхэд ямар нэгэн шүүлтүүргүйгээр мэдээ, мэдээллийг авах, гэмт хэргийн хохирогч болох тохиолдол байгаа тул ийнхүү арга хэмжээг авч буйгаа зарлажээ.³

Тус хуулийн дагуу нийгмийн сүлжээний платформ хөгжүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд 16-аас доош насны хүүхдийг нэвтрүүлэхгүй, хаяг үүсгэхгүй байх үүрэг хүлээсэн бөгөөд уг үүргээ биелүүлээгүй бол нийгмийн сүлжээний компаниудад 33 сая ам.доллар хүртэл торгуулийн шийтгэл оногдуулахаар хуульчилсан байна. Энэ нь тухайн хүүхэд болон эцэг, эхэд ямар нэгэн үүрэг, хариуцлага хүлээлгэхгүй байх талаар мөн дурджээ.

16-аас доош насны хүүхдүүдэд нийгмийн сүлжээ ашиглахыг хориглосны дараа нийгмийн сүлжээний платформууд 4.7 сая хаягийг устгасан байна. <https://www.pbs.org/>

Франц улс:

2023 оны 6-р сарын 29-нд нийгмийн сүлжээнд хүүхдийн бүртгэлийг зохицуулах хууль баталсан. Үндсэн агуулга:

- 15-аас доош насны хүүхэд нийгмийн сүлжээнд аккаунт нээхэд эцэг эхийн зөвшөөрөл заавал шаардлагатай.
- Платформууд хэрэглэгчийн насыг шалгах, эцэг эхийн зөвшөөрлийг баталгаажуулах систем нэвтрүүлэх ёстой.⁴
- Мөн 2026 оны 1-р сард Хүүхдийн сэтгэцийн эрүүл мэнд, кибер дарамт, хорт контентоос хамгаалах зорилготой шинэ хууль баталсан ба 2026 оны 9-р сард хичээлийн шинэ жилээс хэрэгжиж эхэлнэ. Үндсэн агуулга:
- 15-аас доош насны хүүхдэд нийгмийн сүлжээ ашиглахыг хориглох

³ /<https://www.pbs.org/newshour/world/french-lawmakers-approve-ban-on-social-media-for-kids-under-15/>

⁴ /https://www.lemonde.fr/en/france/article/2023/06/29/france-requires-parental-consent-for-under-15s-on-social-media_6039514_7.html/

- Платформууд нас баталгаажуулах (age-verification) систем нэвтрүүлэх⁵
- Зөрчил гаргасан платформд компанийн жилийн орлогын 1% хүртэл торгууль ногдуулах боломжтой.⁶

Норвеги улс:

Францын 15 насны “digital majority” загвартай ойролцоо 1) нийгмийн сүлжээний насны босгыг 15 нас болгох, 2) нас баталгаажуулах систем нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Их Британи улс:

2023 онд Online Safety Act 2023 хуулийг баталсан. Энэ хуулиа насны шууд хориг тавиагүй боловч хүүхдийн хамгаалалт маш хатуу, платформууд аюултай контент устгах үүрэгтэй, мөн нас баталгаажуулах механизм шаарддаг.

Америкийн нэгдсэн улс:

Холбооны түвшинд ижил хууль байхгүй ч олон мужид ижил санаачилга гарсан. Жишээ нь:

Utah Social Media Regulation Act (2023)

Arkansas Social Media Safety Act (2023) Эдгээр нь хүүхэд аккаунт нээхэд эцэг эхийн зөвшөөрөл авах, нас баталгаажуулах систем шаарддаг.

Индонез улс:

2026 онд 16-аас доош насныханд нийгмийн сүлжээ хориглох бодлого хэрэгжүүлэхээр болсон. YouTube, TikTok, Facebook, Instagram зэрэг платформд нас баталгаажуулах шаардлага тавина.

Энэтхэг (Каранатака муж):

6-аас доош насныханд социал хэрэглээг хориглох шийдвэр гаргасан.

Бразил:

2025 онд баталсан хууль: 16-аас доош насныхны аккаунтыг эцэг эхтэй холбох платформууд нас баталгаажуулах систем ашиглах, зөрчвөл 50 сая реал хүртэл торгууль ногдуулах


⁵ /<https://www.pbs.org/newshour/world/french-lawmakers-approve-ban-on-social-media-for-kids-under-15/>

⁶ /<https://iclg.com/practice-areas/cybersecurity-laws-and-regulations/France/>


2. Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах Монгол Улсын эрх зүйн орчин /нийтлэг зохицуулалт/

- Эрүүгийн хууль /2015/- 16.9 дүгээр зүйлийн 1 “Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан”
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /2021/- 29.1 “Мэдээллийн эзнээс хуульд заасан үндэслэл болон анх зөвшөөрөл авснаас өөр зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахыг хориглоно”
- Хүүхэд хамгааллын тухай хууль/2024/
 - 8.6.-т “Интернэтийн орчинд эрх эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээд хүүхдэд зориулсан тусгай багцын үйлчилгээтэй байх бөгөөд үйлчилгээний гэрээ байгуулахдаа тухайн этгээдийн асран хамгаалалд 18 нас хүрээгүй хүүхэд байгаа эсэхийг заавал асууж, насанд хүрэгчдэд зориулсан тусгай сувгийн үйлчилгээг хэрэглэх эсэхийг тохиролцоно”
 - 25.2-т “Хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц цахим тоглоом, хүүхдэд хортой агуулга, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд түгээх, хэрэгжилтэд нь хяналт тавих чиг үүргийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хэрэгжүүлнэ”
 - 25.3-т “Хүн, хуулийн этгээд хүүхдийг цахимаар урхидах, дээрэлхэх, дарамтлахыг хориглоно.
 - 25.4-т “Хүн, хуулийн этгээд хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, эсхүл хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийн зураг, дуу, дуу-дүрсний бичлэг агуулсан контент, мэдээ, мэдээлэл, бүтээлийг олон нийтэд түгээхийг хориглоно”.


3. Судалгаа /1129 хүүхэд/



1. Нийгмийн сүлжээнд хоногт өнгөрүүлдэг цаг




2. Интернет ашигладаг зорилго



3. Танихгүй хүнд хариу өгдөг эсэх




4. Сөрөг захидал авч байсан эсэх




5. Сөрөг захидлын төрөл




6. Буруу зүйлд уруу татсан мэдээлэлтэй таарч байсан эсэх




7. Хувийн мэдээллээ хамгаалах тохиргоо хэрэглэдэг эсэх



8. Цахим хэрэглээний цагт тавих эцэг, эхийн хяналт



09. Цахим хэрэглээний агуулгад тавих эцэг, эхийн хяналт




10. Цахим орчинд гутаан доромжлогдвол ямар арга хэмжээ авах вэ




10-18 насны нийт 1129 хүүхдээс судалгаа авахад интернэтийг 2-4 цаг хүртэлх хугацаанд хэрэглэдэг, интернэтийг ихэвчлэн нийтийн сүлжээ (Фейсбүүк, инстаграмм, твиттер, youtube, Tik tok зэрэг)-нд холбогдох, найз нөхдийн харилцаа холбоо тогтооход хэрэглэдэг, интернэт хэрэглээний цаг болон агуулгад эцэг, эхийн хяналт сул байдаг, интернэтэд буруу зүйлд уруу татсан агуулга бүхий мэдээ, мэдээлэлтэй тааралддаг, нийгмийн сүлжээнд гутаан доромжилж ялгаварлан гадуурхвал нийт хүүхдүүдийн 59 хувь нь эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хандахаар байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

3. Судалгаа/ Эцэг эх асран хамгаалагчид/


1. Хүүхдийнхээ цахим хэрэглээнд хяналт тавьдаг эсэх




2. Цахим мэдээллийн тохиргооны талаарх таны мэдлэг




3. Таны хүүхэд нийгмийн сүлжээнд дарамт, шахалтад өртөж байсан уу?



4. Таны хүүхэд цахим дарамтад өртөж байсан тухай гэр бүлийнхэндээ хэлдэг үү?



5. Та нийгмийн сүлжээнд хүүхдийн хамгааллын талаар хэр мэдээлэлтэй вэ?



Нийт 253 эцэг, эхээс 6 төрлийн асуулга бүхий судалгаа авахад эцэг эхийн хяналт сул байдаг, хүүхдүүд нийгмийн сүлжээнд дарамт шахалтад өртөж байгаагүй, хүүхэд цахим дарамтад өртөж байсан тухай гэр бүлийнхэндээ хэлдэггүй, нийгмийн сүлжээнд хүүхэд хамгааллын талаар мэдлэг дунд эсхүл бага зэрэг гэсэн хариултуудыг дийлэнх нь сонгосон байгаа бөгөөд тусгайлсан хууль гаргах нь зүйтэй гэсэн саналыг дийлэнх нь гаргасан байна.

4. Хуулийн төсөл /5 бүлэг 54 заалт/

Нэгдүгээр бүлэг: Хуулийн зорилт, Тус харилцааг зохицуулж буй хууль, тогтоомж, Хуулийн үйлчлэх хүрээ, Хуулийн нэр томьёо

-Зорилт: Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг цахим дарамт, донтолт, заналхийлэл, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааны тогтолцоо, эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулах.

-Зохицуулах хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Харилцаа холбооны тухай хууль
- Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Кибер аюулгүй байдлын тухай хууль
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
- Энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт

-Хуулийн нэр томьёо:

- “насны хязгаартай хэрэглэгч” гэж 16 нас хүрээгүй Монгол Улсын иргэн, Монгол улсад суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;
- “нийгмийн сүлжээ” гэж интернет сүлжээ ашиглан олон нийтийн дунд мэдээлэл түгээх, олж авах, хуваалцах, харилцан солилцох, сурталчлан таниулах, сэтгэгдэл, санал бодлоо илэрхийлэх, харилцах боломж бүхий цахим хэрэглүүр /аппликэйшн/, платформ;
- “насны хязгаартай нийгмийн сүлжээ” гэж энэ хуулийн 5.1-т заасныг;
- “насны хязгаартай нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч” гэж энэ хуулийн 4.1.3-т заасан “насны хязгаартай нийгмийн сүлжээ” эрхлэгч хүн, хуулийн этгээдийг.

Хоёрдугаар бүлэг: Насны хязгаартай нийгмийн сүлжээ

Насны хязгаартай нийгмийн сүлжээ:

- Насны хязгаартай нийгмийн сүлжээний жагсаалтыг Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- Жагсаалтыг батлахдаа Монгол Улсаас бүртгэлтэй 100,000 буюу түүнээс дээш тооны хэрэглэгчтэй нийгмийн сүлжээг хамруулна.
- Цахим сургалт, хурлын платформ, файл хадгалах болон хуваалцах үйлчилгээ болон бусад хуулиар зөвшөөрөгдсөн нийгмийн сүлжээ, нийгмийн сүлжээний хүүхдэд зориулсан тусгай хувилбар нь насны хязгаартай нийгмийн сүлжээнд хамаарахгүй.
- Насны хязгаартай нийгмийн сүлжээнд 16 нас хүрээгүй хүүхдэд бүртгэл үүсгэхийг хориглоно.

Нийгмийн сүлжээ эрхлэгчийн эрх үүрэг:

- Монгол улсын нутаг дэвсгэрээс хэрэглэгч бүртгүүлэх хүсэлтийг баталгаажуулахад бүртгэлтэй гар утасны дугаарыг ашиглана;
- Хэрэглэгчийн нас баталгаажуулах зорилгоор ашигласан, цуглуулсан мэдээ, мэдээллийг нэн дариу устгах бөгөөд аливаа хэлбэрээр гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно;
- Хэрэглэгч заасан хугацаанд өөрийн насыг баталгаажуулаагүй тохиолдолд нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч нь тухайн хэрэглэгчийн бүртгэлийг түр хязгаарлах, эсхүл үйлчилгээг ашиглах боломжийг түдгэлзүүлэх;
- Хэрэглэгчийг танин баталгаажуулах зорилгоор холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран ажиллах;
- Насны хязгаартай нийгмийн сүлжээний жагсаалтад хамаарах гадаад улсын нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч Монгол улсыг хариуцсан төлөөлөгчийг томилох

Бусад этгээд хүүхдийн аюулгүй байдлыг хангах.

- Аливаа этгээд насны хязгаартай нийгмийн сүлжээнд 16 нас хүрээгүй хүүхдэд бүртгэл үүсгэх боломжоор хангах болон өөрийн бүртгэлтэй хаягийг ашиглуулахыг хориглоно.
 - Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч 16 нас хүрээгүй хүүхдэд баталгаажуулалтын кодыг илгээхгүй байх техникийн боломжийг бүрдүүлнэ.
- Гуравдугаар бүлэг: Насны хязгаартай нийгмийн сүлжээг зохицуулах талаар төрийн байгууллагын чиг үүрэг:
- Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг:
- Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаар төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
 - Нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийг энэ хуульд заасан үүргээ биелүүлэхэд хамтран ажиллах;
 - Гадаад улсын нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчтэй хамтран ажиллах;
 - Хуульд заасан бусад.

Бусад төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг:

- Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага багш, ажилтан боловсролын сургалтын үйл ажиллагаанд сурагчидтай харилцах, мэдээлэл солилцох, хамтран ажиллахдаа хүүхдэд зориулсан тусгай хэрэгцээний платформыг ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- Гэр бүл, хөдөлмөр нийгэм, хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах хууль тогтоомжийг олон нийтэд таниулан сурталчлах, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлнэ.

Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүрэг:

- Энэ хуулийн 6.1.3, 6.1.5-д заасан үүргээ биелүүлээгүй тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтийг үндэслэн технологийн арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Энэ хуулийн 11.1.9-д заасан урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулахад Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвд дэмжлэг үзүүлэх;
- хуульд заасан бусад.
- Нийгмийн сүлжээний хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулахаас өмнө нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчид эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтийг хүлээн авсны дараа нэн даруй мэдэгдэл хүргүүлнэ.

Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн чиг үүрэг:

- Хүүхдийн эрхийг зөрчсөн зөрчилтэй контентын талаарх хүсэлт, гомдлыг хүн, хуулийн этгээдээс хүлээн авч бүртгэн, холбогдох арга хэмжээг авах;
- Гэмт хэрэг үйлдэх сэдэл агуулсан контентын талаарх түгээлтийг эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтийг үндэслэн технологийн арга хэмжээ авч хязгаарлах, холбогдох арга хэмжээг авах;
- Нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч нь хуульд заасан шаардлагыг хангаж буй эсэхэд хяналт тавих;
- Хууль бус контент түгээж байгаа этгээд, бүлэглэлийг илрүүлэх, таслан зогсоох;
- Гомдол, мэдээллийн дагуу авсан арга хэмжээний талаарх тайланг жил бүр олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх;
- Хүүхдийг дарамталсан, айлган сүрдүүлсэн, доромжилсон, дээрэлхсэн зүй бус агуулга бүхий мэдээ, мэдээллийг нийгмийн сүлжээ ашиглан илгээх, бусдад түгээх асуудлаас урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулах.

Дөрөвдүгээр бүлэг: Гомдол мэдээлэл гаргах, хянан шийдвэрлэх

- Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг зөрчиж байгаа талаар ирүүлсэн гомдол, мэдээллийг нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, хууль сахиулагч, нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч хүлээн авч шалгах, эсхүл шаардлагатай арга хэмжээг хуульд заасны дагуу авна.
- Энэ зүйлд заасан гомдол, мэдээллийг хүлээн авах, илрүүлэх зорилгоор яаралтай тусламжийн утас, цахим шуудан ажиллуулж болно.
- Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийн зөрчлийн талаар ирүүлсэн гомдол, мэдээлэл гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу шалган шийдвэрлэх бөгөөд тухайн асуудлыг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан болон орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллагад заавал мэдэгдэнэ.
- Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрх зөрчсөн, эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа талаар гомдол, мэдээллийг хүлээн авсан ажилтан, албан тушаалтан тухайн мэдээллийг газар

дээр нь шалгах, үнэлэх явцад хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул шууд учирсан, эсхүл уг нөхцөл бүрдсэн бол яаралтай арга хэмжээг авч хэрэгжүүлэх саналыг эрх бүхий албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.

- Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийн эсрэг гэмт хэргийг цагдаагийн байгууллага холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

Тавдугаар бүлэг: Бусад зүйл

Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх хэсэгт “Харилцаа холбооны тухай хууль тогтоомж,” гэсний дараа “Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хууль тогтоомж” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Харилцаа холбооны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

30 дугаар зүйлийн 30.2.4 дэх хэсэг:

“30.2.4. Нийгмийнд сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуульд заасан арга хэмжээ аваагүй нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээг хэрэгжүүлэх;”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт:

“Энэ хууль болон бусад хуульд заасны дагуу нэг удаа хэрэглэгчийг танин мэдэх зорилгоор”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

5. Нэмэлт өөрчлөлт оруулах хууль /4 хууль 11 заалт/

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлд доор дурдсан хэсэг нэмсүгэй:

“101.16 нас хүрээгүй хүүхдэд бүртгэл үүсгэсэн бол насны хязгаартай нийгмийн сүлжээ эрхлэгч хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нийгмийн сүлжээний жагсаалтыг батална.

2 дугаар зүйл. Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийгмийн сүлжээний жагсаалтад орсон платформын үйлчилгээ эрхлэгч хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, хуулийн хэрэгжилтийг хангах зорилго бүхий ажлын хэсгийг бусад төрийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

3 дугаар зүйл. Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийг дагаж мөрдсөнөөс хойш энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан Ажлын хэсгийг татан буулгана.

4 дүгээр зүйл. Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан нийгмийн сүлжээний жагсаалтад багтсан нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч хүн, хуулийн этгээд Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө насны хязгаартай хэрэглэгчийг танин мэдэх, хориглосон этгээдийг өөрийн сүлжээнд нэвтрүүлэхгүй байх арга хэмжээг авсан байна.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.